

УЛААНБААТАР ХОТЫН СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

1993 оны 6 сарын 28-өдөр

дугаар 34.

Улаанбаатар хот

"УЛААНБААТАР" КЛУБЫН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ДҮРМИЙГ ЗӨВШӨӨРӨХ
ТУХАМ

ТУШААХ НЬ:

1. Монголын далай сонирхогчдын нийгэмлэгийн даргын тушаалаар батлагдсан Хүүхэд-залуучуудын спорт-сургалт, аялал-жуулчлал, сурталчилгаа эрхэлсэн "Улаанбаатар" клубын дүрмийг зөвшөөрч цаашид аж ахуйн тооцоон дээр 1993.6.15-наас эхлэн ажиллуулахыг тус клубын эрхлэгч Н.Зулбадрахад хариуцуулсугай.

2. Монголын далай сонирхогчдын нийгэмлэг, "Далайчин" компани, бусад ивээн тэтгэгч байгууллагуудын тусламж дэмжлэгтэйгээр ширээний теннис, талбайн теннис, усан спорт, усан аялал-жуулчлал, хүүхдийн аялал жуулчлал зэргийг удирдах салбар зөвлөлийг байгуулан ажиллуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

3. "Улаанбаатар" клубын тамга, дэмдэг, бусад бичиг баримтыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж тусгай данс нээж үр ашигтай ажиллахыг /Н.Зулбадрах/-д үүрэг болгосугай.



Оршан Зүмүр СОЛНОМЗУНШУЙ